Уул уурхайн ашигт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг аж, ахуйн нэгж байгууллагууд үйлдвэрийн технологийн явцад Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг судлах, судалгааны үр дүнд үндэслэн гарч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, холбогдох чиг үүрэг бүхий газарт хүргэх зорилго бүхий ажлын хэсэг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2023 оны А/160 тоот тушаалаар байгуулагдаж Монгол орны хэмжээнд одоо ашиглагдаж байгаа нийт 173 уурхайд очиж газар дээр нь ажилласан.

Тус ажлын хэсгийн хийх ажлын хүрээнд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байрлах нүүрсний уурхайн талбайд 2023 оны 05-р сарын 23-ны өдөр ажлын хэсгийн бүрэлдэхүүн газар дээр нь ажилласан.

Энэхүү тайлан нь үндсэн Оршил, 6 бүлэг, 21 дэд бүлэг, дүгнэлт, зөвлөмж гэсэн нийт 27 хэсгээс бүрдэнэ.

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	“Говийн шандаст хүлэг” ХХК
Регистрийн дугаар	6463932
Улсын бүртгэлийн дугаар	9019090139
Монгол орны сав газрын ангиллаар	Умард говийн гүвээт халхын дундад тал
Байршил	Дорноговь аймгийн Даланжаргалан сум
Ордын нэр	Алагтогоогийн нүүрсний орд
АМ төрөл	Нүүрс
Ашиглалтын ТЗ дугаар	MV-019331
Хяналт шинжилгээний хугацаа	2023.05.23-2023.06.15

Алаг тогоогийн нүүрсний ордын Хойд Элдэв, Хойд Алаг тогоо хэсэгт зэрэг уулын ажил явуулна. Жилд 1.5 сая т нүүрс олборлоно. Ил уурхайгаас олборлох нүүрсийг төслийн талбайгаас 25 км зайд орших төмөр замын 25-р зөрлөг дээр байрлах нүүрс баяжуулах үйлдвэрүүдэд худалдан борлуулна. Хойд Алаг тогоо хэсгийн талбай дээр өнгөрөх 110кВ цахилгаан дамжуулах агаарын шугамыг ил уурхайн талбайгаас аюулгүй зайд шилжүүлэх угсарна. Ил уурхайн олборлолт, хөрс хуулалт, тэсэлгээ, нүүрс тээврийн ажлыг мэргэжлийн туслан гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлнэ.

Алаг тогоогийн ордын Хойд Элдэв, Хойд Алаг тогоо хэсгүүдийг 7 жил ашиглана. Төслөөр Хойд Элдэв хэсэгт 4 тусдаа ил уурхайн ухаш, Хойд Алаг тогоо хэсэгт 1 ил уурхайн ухаш, нийт 5 ил уурхай үүснэ. Ашиглалтын эхний жилээс тухайн 2 хэсэгт зэрэг ашиглалт явуулах бөгөөд Хойд Элдэв хэсэгт одоо ашиглалт явуулж буй баруун урд жигүүрийн (8А блок) ил уурхай, түүний зүүн талд шинээр үүсэх ил уурхайг ашиглалтын 3-р жилд нээж (11В блок) болон ашиглалтын 5-6-р жилд зүүн хойд 2 ил уурхай (12В, 13А блокууд) гэсэн дараалаар, Хойд Алаг тогоо хэсэгт ашиглалтын эхний жилээс 7-р жилийг дуустал нүүрсний уналын дагуу ил уурхайг тэлж ашиглалт явуулна.

БҮЛЭГ 2. УСНЫ ЧАНАРЫН СУДАЛГАА

2.1 ХЭЭРИЙН СУДАЛГАА

Усны чанарт хяналт шинжилгээ хийх зорилгоор 2023 оны 5 дугаар сарын 23-ны өдөр үйлдвэрийн талбайн шүүрлийн 3 , унд ахуйн 2 худаг болон бохир усны 3 нийт 8 уст цэгээс сорьц цуглуулж газар дээр усны орчин (pH), эрдэсжилт (TDS), цахилгаан дамжуулах чанар (Cond), ууссан хүчилтөрөгч (DO), исэлдэх ангижрах чанар (ORP), булингар, давсжилт зэрэг үзүүлэлтийг хэмжсэн Хэмжилт хийсэн уст цэгүүдийн газарзүйн солбицлыг -т, байршлын зураглалыг Error: Reference source not found -т харуулав.

Хүснэгт 1. Усны чанарын хяналт шинжилгээ хийсэн солбицол

Дээжийн код	Дээж авсан газрын нэр	Стандарт	Өргөрөг	Уртраг
LW-602	Хойд элдвийн уурхайн шүүрлийн ус	MNS4586:1998	46^{0}7’50.229”	109^{0}0’3.952”
LW-603	Хойд элдвийн уурхайн шүүрлийн ус	MNS4586:1998	46^{0}7’57.392”	109^{0}0’2.036”
LW-604	Хойд алаг тогоо, Карьерын шүүрлийн ус	MNS4586:1998	46^{0}11’24.107”	109^{0}0’40.65”
GW-605	Унд ахуйн гүний худгийн ус	MNS 0900:2018	46^{0}8’19.02”	108^{0}59’18.957”
GW-608	Элдэв баг, Малчдын худаг	MNS 0900:2018	46^{0}8’2.088”	108^{0}59’9.741”
WW-609	Кемпийн ахуйн бохир ус	MNS 4943:2014	46°8'20.688"	108°59’18.803"
WW-607	Баяжуулах үйлдвэрийн эргэлттийн сангаас татсан ус	MNS 4943:2014	46°7'54 823"	108°59’40.789”
WW-606	Баяжуулах үйлдвэрийн хаягдал ус	MNS 4943:2016	46°7'54 823"	108°59’40.789”

MNS 4586 : 1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага
MNS0900:2018 Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал, Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага чанар, байдлын үнэлгээ
MNS4943:2015-Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага



3

ураг 1. Усны дээж авсан цэгийн байршил

2.2 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Уурхайн талбай орчмын усны чанар, төлөв байдлыг тодорхойлох, хээрийн судалгааны ажлын үр дүн болон өмнө хийгдсэн судалгааны ажил, холбогдох мэдээ, материалуудыг Монгол улсад мөрдөгдөж буй гадаргын болон гүний усны стандартын ЗДХ-нд харьцуулсан мэдээн дээр үндэслэн энэхүү тайланг боловсруулав.

Усны чанарын үнэлгээ - Гадаргын усны химийн чанар, найрлагыг үнэлэхдээ гол ионуудын агууламжийг үндэслэн О.А.Алекины ангиллыг ашигласан.

Тус ангиллаар

Анионы зонхилох байдлаар нь:

- Гидрокарбонат, карбонат
- Сульфат
- Хлорид

Катионы зонхилох байдлаар

- Кальци
- Магни
- Натрийн гэж тус тус ангилдаг бөгөөд дараах 4 төрөлд хуваж авч үзнэ. Үүнд:

  1-р төрөл: $HCO_3^- > Ca^{2+} + Mg^{2+}$ (энэ төрлийн ус нь ихэвчлэн сул шүлтлэг, цэнгэг, зөөлөн шинж чанартай байна)

  2-р төрөл: $HCO_3^- < Ca^{2+} + Mg^{2+} < HCO_3^- + SO_4^{2-}$ (энэ төрөлд бага эрдэсжилт бүхий нуур, голын ус багтдаг)

  3-р төрөл: $HCO_3^- + SO_4^{2-} < Ca^{2+} + Mg^{2+}$ эсвэл $Cl^- > Na^+ + K+$ (энэ төрлийн усанд далай, тэнгис, эрдэсжилт ихтэй ус багтана)

4-р төрөл: HCO_3^- = 0 (энэ төрлийн ус нь хүчиллэг бөгөөд ихээхэн бохирдсон уул уурхай болон үйлдвэрийн ус багтдаг)

Усны хатуулаг: Усны хатуулгийг ууссан кальци (Ca^{2+}) болон магнийн (Mg^{2+}) ион үүсгэдэг ба нийт хатуулгийн хэмжээ нь кальци, магнийн ионы концентрацийн нийлбэрээр тодорхойлогдоно. (Дорж, 2005). Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандарт -д хатуулгийн зөвшөөрөгдөх хүлцэх дээд агууламж 7 мг-экв/л байдаг бол хатуулгийн зэргээр 1.50 мг-экв/л-ээс бага бол маш зөөлөн, 1.51 – 3.00 мг-экв/л бол зөөлөн, 3.01 – 5.00 мг-экв/л бол зөөлөвтөр, 5.01 – 7.00 мг-экв/л бол хатуувтар, 7.01– 9.00 мг-экв/л хатуу, 9.01 мг-экв/л -ээс их бол маш хатуу гэсэн ангилалд тус тус хамаарагдана[1].

Усны эрдэсжилт: Усны эрдэсжилтийг нийт катион болон анионы нийлбэрээр тодорхойлох ба Монгол Улсын ундны усны MNS 0900:2018 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээ 1000 мг/л-ээс ихгүй байна. Байгалийн усыг эрдэсжилтээр нь ангилсан олон ангилал байдгаас А.М.Овчинниковын ангиллыг ерөнхийд нь баримтлан унд, ахуйн болон малын усны нормыг харгалзан дараах байдлаар ангилдаг. Эрдэсжилт нь 200 мг/л-ээс бага байвал нэн цэнгэг буюу ялимгүй эрдэсжилттэй, 210 – 500 мг/л бол цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, 510-1000 мг/л бол цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, 1100-3000 мг/л бол давстайвтар буюу их эрдэсжилттэй, 3000 – 7000 мг/л бол давстай буюу шорвогдуу, 7100 мг/л-ээс дээш бол их давстай буюу шорвог гэсэн ангилалд хамаарагдана[2].

Усны чанарыг үнэлэхдээ Монгол Улсын Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал, Ундны ус, Эрүүл ахуйн шаардлага чанар, байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандарт болон Усан орчны чанарын үзүүлэлт, Ерөнхий шаардлага MNS 4586:1998 стандартуудыг баримталдаг. Харин бохир усны микробиологийн үзүүлэлтийг үнэлэхдээ MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, Хаягдал усны ерөнхий шаардлага стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээг баримтална.

2.3 СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.3.1 Химийн шинжилгээний дүн

Шинжилгээнд авсан 2 худаг болон шүүрлийн 3 уст цэгийн зонхилох ионуудын химийн шинжилгээний үр дүнг Хавсралт 1-т харуулав. Химийн найрлагыг Пайпер диаграммаар Зураг 2, гол ионуудыг харьцуулсан Штиффийн диаграммаар Зураг 3-т, эрдэсжилт, болон хатуулгийн агууламжийг MNS 0900:2018 стандарттай харьцуулав.

[1] Жавзан, Ч. “Хараа голын дунд хэсгийн цутгал голуудын усны чанарын асуудал.” Proceedings of the Mongolian Academy of Sciences, (2018).

[2] Дорж, Д., Даваасүрэн, С., Даржаа, Ц. Хүрээлэн буй орчны химийн анализ. Улаанбаатар: МУИС, 2005.



Зураг 2. Усны гол ионуудын найрлагын харуулсан пайпер диаграмм



Зураг 3. Усны сорьцууд дэх гол ионуудыг харьцуулсан Штифийн диаграм

LW-602 (Элдэв баг, Хойд элдэвийн уурхайн шүүрлийн ус): Химийн бүрэлдэхүүнээрээ сульфат ангийн, магнийн бүлгийн, II-р төрлийн, чанарын хувьд давстайвтар, маш хатуу ус байна. Шинжилсэн дүнгээс харахад нийт эрдэсжилт дундаа хлор болон сульфатын ион Усан орчны чанарын үзүүлэлт, Ерөнхий шаардлага MNS 4586:1998 (цаашид MNS 4586:1998 гэх) стандартын хүлцэх дээд агууламжтай харьцуулж үзэхэд стандартад заагдсан дээд хэмжээнээс хэтэрсэн байна.

LW-603 (Хойд элдвийн уурхайн шүүрлийн ус): Химийн бүрэлдэхүүнээрээ сульфат ангийн, магнийн бүлгийн, III-р төрлийн, чанарын хувьд давстайвтар, маш хатуу ус байна. Шинжилсэн дүнгээс харахад нийт эрдэсжилт дундаа хлор болон сульфатын ион MNS 4586:1998 стандартын хүлцэх дээд агууламжтай харьцуулж үзэхэд стандартад заагдсан дээд хэмжээнээс хэтэрсэн байна.

LW-604 (Хойд алаг тогоо, Карьерын шүүрлийн ус): Химийн бүрэлдэхүүнээрээ сульфат ангийн, натрийн бүлгийн, II-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, хатуувтар ус байна. Шинжилсэн дүнгээс харахад нийт эрдэсжилт дундаа сульфатын ион MNS 4586:1998 стандартын хүлцэх дээд агууламжтай харьцуулж үзэхэд стандартад заагдсан дээд хэмжээнээс хэтэрсэн байна.

GW-605 (унд ахуйн худаг): Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонат ангийн, натрийн бүлгийн, I төрлийн, цэнгэгдүү, хатуувтар ус байна. Химийн шинжилгээний үр дүнг Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 (цаашид MNS 0900:2018 гэх) стандартын хүлцэх дээд агууламжтай харьцуулж үзэхэд стандартад заагдсан дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.

GW-608 (малчдын худаг): Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонат ангийн, натрийн бүлгийн, II төрлийн, цэнгэгдүү, хатуу ус байна. Химийн шинжилгээний үр дүнг MNS 0900:2018 стандартын хүлцэх дээд агууламжтай харьцуулж үзэхэд магнийн ионы агууламж стандартад заагдсан дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.

2.3.2 Усны эрдэсжилт

Судалгааны талбайн хяналтын цооногуудын усны эрдэсжилтийг MNS 4586:1998 болон MNS 0900:2018-ын хүлцэх дээд агууламжтай харьцуулан Зураг 4 -т харуулав. Усны сорьцууд харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй буюу цэнгэгдүүгээс их эрдэсжилттэй буюу давстайвтар (995-2917 мг/л) ангилалд хамаарагдаж байна.



Зураг 4. Усны сорьцуудын эрдэсжилт, мг/л

Шинжилгээний дүнгээс харахад шүүрлийн усны 3 уст цэгийн сульфатын ионы агууламж MNS 4586:1998 стандартын хүлцэх дээд агууламжаас 2.8-8.1 дахин, хлоридын ионы агууламж 1.1 дахин хэтэрсэн үзүүлэлттэй байна.

2.3.3 Ерөнхий хатуулаг

Уст цэгүүдийн сорьцын химийн шинжилгээний дүнг MNS 900:2018 стандартын хүлцэх дээд агууламжтай харьцуулж үзэхэд хатуулгийн агууламжаар LW-602, LW-603 буюу Хойд элдвийн уурхайн шүүрлийн усны сорьц тус стандартын хүлцэх дээд агууламжаас 2.9-6.1 дахин (20.77-42.75 мг-экв/л), GW-608 буюу малчдын худгийн усны сорьц ялимгүй буюу 1.03 дахин хэтэрсэн агууламжтай байна. Харин LW-604 (Хойд алаг тогоо, Карьерын шүүрлийн ус) болон GW-605 (унд ахуйн худгийн ус) MNS 900:2018 стандартын хүлцэх дээд агууламж хэмжээнд байна.

Хатуулгаар нь агилж үзэхэд хатуу ангилалд 1 сорьц (7.27 мг-экв/л) хатуувтар ангилалд 2 сорьц (5.24-5.25 мг-экв/л), маш хатуу (20.77 мг-экв/л) ангилалд 2 сорьц хамаарагдаж байна.(Зураг 5).



Зураг 5 Усны сорьцуудын хатуулаг, м-экв/л



Зураг 6 Хатуулаг дахь кальци,магнийн эзлэх хувь

2.3.4 Бохир усны хими, микробиологийн шинжилгээний дүн

Кемпийн Бохир усны микробиологийн шинжилгээний дүнг хүснэгт 2-т харуулав. Хэмжилтийн үр дүнг “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага”- MNS4943:2015 стандарттай харьцуулан үзүүлэв.

Хүснэгт 2. Хаягдал усны микробиологийн шинжилгээний үр дүн

Үзүүлэлт	MNS 4943:2015	2023		
		WW-609	WW-607	WW-606
pH	6.0-9.0	8.02	7.51	7.42
NH4 + (mgN/L)		50.88	2.78	6.01
Cl-(mg/l)		191.43	489.21	464.39
SO4 2+ (mg/l)		0.13	653.68	724.52
TSS, (mg/l)	<30	400	200	800
COD,(mg/l)	<50	553	555.5	1133
BOD (mg/l)	<20	212.69	213.65	435.76
NO2 (mgN/L)		233.52	0.02	0.06
NO3 (mgN/L)		0.05	0.49	1.73
Гэдэсний бүлгийн эмгэг төрүүлэгч	Илрэхгүй	ИЛЭРСЭН	ИЛЭРСЭН	ИЛЭРСЭН

Шинжилгээний дүнгээс харахад бохир усны 3 уст цэгийн умбуур бодисын (TSS) агууламж хүлцэх дээд хэмжээнээс 6.6-26.6 мг/л дахин, химийн хэрэгцээт хүчилтөрөгч (COD) 11.06-22.6 дахин, биологийн хэрэгцээт хүчил төрөгч (BOD) 10.6-21.8 мг/л дахин хэтэрсэн агууламжтай байгаа бөгөөд MNS4943:2015 стандартад нийцэхгүй байна.

2.3.5 Бичил элементийн шинжилгээний дүн

Уст цэгийн усны сорьцонд хийсэн бичил элементийн шинжилгээний дүнг MNS 0900:2018, MNS4586:98 болон MNS4943:2015 стандартын хүлцэх дээд агууламжтай харьцуулав. Уст цэгүүдийн сорьцонд 20 бичил элемент агууламжийг тодорхойлсон. Зарим уст цэгийн сорьцонд бичил элемент агууламж багажийн тодорхойлох хязгаараас бага буюу илрээгүй. Илэрсэн элементүүдийн үр дүнг -т харуулав. Шинжилгээний бүрэн үр дүнг хавсралт 1-д тусгасан болно.

Хүснэгт 3. Усны бичил элементийн шинжилгээний дүн /2023он/

Дээжийн код	Дээж авсан газрын нэр	Ba	B	Sr	In	Ta
НЭГЖ		мг/л	мг/л	мг/л	мг/л	мг/л
MNS 0900:2018		0.7	2.4	2.0	-	-

MN S4586:98		**0.7**	**2.4**	**2**	**-**	**-**
MNS 4943:2015		**1.5**	**0.5**	**2**	**-**	**-**
LW-602	Элдэв баг, Хойд элдвийн уурхайн шүүрлийн ус	0.0043	0.0069	0.0627	0.0741	<0.0132
LW-603	Хойд элдвийн уурхайн шүүрлийн ус	<0.0054	0.0067	0.0992	<0.0143	<0.021
LW-604	Хойд алаг тогоо, Карьерын шүүрлийн ус	<0.006	0.0004	0.0032	0.0396	0.0059
GW-605	Унд ахуйн гүний худаг	<0.0063	0.0008	0.0033	0.0462	0.006
GW-608	Элдэв баг, Малчдын худаг	<0.0058	0.0008	0.0034	0.0469	<0.0057
WW-609	кемпийн ахуйн бохир ус	<0.006	0.0075	0.0028	0.0034	<0.0032
WW-607	Баяжуулах үйлдвэрийн эргэлттийн сангаас татсан ус	0.0064	0.0004	0.0146	<0.0053	<0.0103
WW-606	Баяжуулах үйлдвэрийн хаягдал ус	<0.0029	<0.0043	0.0028	<0.0046	0.001

Нийт уст цэгийн усны сорьцонд бичил элементийн шинжилгээг 20 элементээр шинжлэхэд MNS 0900:2018, MNS4586:98 болон MNS4943:2015 стандартын хүлцэх дээд агууламжаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.

ДҮГНЭЛТ

Уул уурхайн ашигт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах үйл ажиллагаа эрхэлдэг аж, ахуйн нэгж байгууллагууд үйлдвэрийн технологийн явцад Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг судлах, судалгааны үр дүнд үндэслэн гарч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, холбогдох чиг үүрэг бүхий газарт хүргэх зорилго бүхий ажлын хэсэг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2023 оны А/160 тоот тушаалаар байгуулагдаж 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Говийн шандаст хүлэг ХХК-ийн Алтантогоогийн нүүрсний орд ашиглах уурхайн талбайд газар дээр нь ажилласан.

Тус уурхайн талбайд байрлах 3 шүүрлийн ус, унд ахуйн 1 худаг, баяжуулах үйлдвэрийн эргэлтийн сан болон хаягдал усны 2, бохир усны 1 уст цэг болон малчдын худгийн 1 уст цэгээс нийт 8 сорьц цуглуулсан. Дээрх уст цэгийн сорьцонд хийсэн химийн шинжилгээний үр дүнг үндэслэн усны чанарт дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Шүүрлийн усны 3 уст цэгийн химийн шинжилгээний дүнгээс харахад сул шүлтлэг орчинтой (pH 7.4-8.3), эрдэсжилтийн агууламжаар цэнгэгдүүгээс-их эрдэсжилттэй буюу давстайвтар ангилалд хамаарагдаж байна (998-2917 мг/л), химийн найрлагын хувьд анионоос сульфат ион, катионоос магни ион давамгайлж ионуудын харьцаа (SO4>Cl> HCO3), (Mg >Ca>Na) байна. Уст цэгүүдийн сорьцын химийн шинжилгээний дүнг дүнг Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын хүлцэх дээд агууламжтай харьцуулж үзэхэд хатуулгийн агууламжаар LW-602, LW-603 хойд элдвийн уурхайн шүүрлийн усны 2 сорьц хүлцэх дээд агууламжаас 2.9-6.1 дахин (20.77-42.75 мг-экв/л) хэтэрсэн үзүүлэлттэй маш хатуу ус байв. Харин LW-604 (Хойд алаг тогоо, Карьерын шүүрлийн ус) хүлцэх дээд агууламж хэмжээнд буюу зөөлөвтөр ус байна.
2. Мөн дээрх шүүрлийн усны 3 уст цэгийн шинжилгээний дүнгээс харахад сульфатын ионы агууламж MNS 4586:1998 стандартын хүлцэх дээд

агууламжаас 2.8-8.1 дахин, хлоридын ионы агууламж 1.1 дахин хэтэрсэн үзүүлэлттэй байна.

3. Унд ахуйн худгийн GW-605 сорьцод хийсэн химийн шинжилгээний дүнгээс харахад тус уст цэгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонат ангийн, кальцийн бүлгийн, I төрлийн цэнгэг, зөөлөвтөр ус байна. шинжилгээний дүнг Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын хүлцэх дээд агууламжтай харьцуулж үзэхэд цахилгаан дамжуулах чанар (Ec) ялимгүй хэтэрсэн (1.4 mSm/cm) мөн их эрдэсжилттэй (1085 мг/л) буюу 1.08 дахин, тэр дундаа магни (Mg) ионы агууламж 1.2 дахин (37.7 мг/л) хэтэрсэн байна. Тиймээс унд ахуйд хэрэглэхэд хүний эрүүл мэндэд тохиромжгүй ус байна.
4. Малчны худгийн GW-608 сорьцод хийсэн химийн шинжилгээний дүнгээс харахад тус уст цэгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонат ангийн, натрийн бүлгийн, II төрлийн цэнгэгдүү, хатуу ус байна. Шинжилгээний дүнг Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын хүлцэх дээд агууламжтай харьцуулж үзэхэд тус стандартын шаардлагыг хангаж байгаа тул хүн, малын унд ахуйн хэрэгцээнд ашиглах боломжтой.
5. Бохир усны 3 уст цэгийн микробиологийн шинжилгээний дүнг “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS4943:2015 стандартын хүлцэх агууламжтай харьцуулж үзэхэд умбуур бодисын (TSS) агууламж хүлцэх дээд хэмжээнээс 6.6-26.6 дахин, химийн хэрэгцээт хүчилтөрөгч (COD) 11.06-22.6 дахин, биологийн хэрэгцээт хүчил төрөгч (BOD) 10.6-21.8 дахин хэтэрсэн агууламжтай байгаа бөгөөд стандартад нийцэхгүй байна.
6. Дээрх 8 уст цэгийн усны сорьц нь бичил элементийн агууламжаар Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартыг хангаж байгаа болно.

ЗӨВЛӨМЖ

1. Цаашид уст цэгүүдийн хяналт-шинжилгээний мэдээллийн дата бааз үүсгэх;
2. Шинжилгээний үр дүнгээр өссөн үзүүлэлтүүдийг тогтмол хянаж, стандартаас өссөн буюу бохирдол үүсгэж байгаа эх үүсвэрийг нарийвчлан тогтоох, нэгэнт үүссэн бохирдлыг бууруулах арга хэмжээг авах;
3. Уул уурхайн олборлолтоос үүсэх морфологийн өөрчлөлтөөс болж хурдас чулуулаг хуримтлагдах хур борооны усаар зөөгдөх эрсдэлтэй тул түүнд хяналт тавьж ажиллах;
4. Хотхоны ахуйн хэрэглээнээс гарч буй бохир усыг бохир ус цэвэрлэх байгууламж ашиглан хаягдал усны стандартад нийцүүлэн цэвэршүүлэх, түүнийгээ зам усалгаа, тоос дарахад ашигла;

5. Газрын доорх ус бохирдох явцыг хянах, хяналт шинжилгээний худгууд байгуулах шаардлагатай. Мониторингийн худгийн шүүр яндангийн диаметр 50-60 мм-ээс багагүй, стандартын хуванцар хоолой байна. Уст давхаргын таазнаас дээш цементэн түгжээтэй хийж, амсрын хэсэгт 159 мм диаметртэй хамгаалалтын ган хоолойг 5-6 м гүнд суулгаж, амсрын хамгаалалтын бетон блок 0.5х0.5х0.8м3 хэмжээтэй цутган, давхар хамгаалалттай цоож бүхий ган таглаа байрлуулна.
6. Гадаргын усны хяналтын цэг байгаа эсэх байхгүй бол нэмэх;
7. Усны тухай хууль түүнийг дагалдан гарсан дүрэм, журмуудыг баримталж шаардлагатай бичиг баримтын бүрдлийг хуулийн хугацаанд хангаж ажиллах;

БҮЛЭГ 3. ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН СУДАЛГАА

3.1 ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

Хээрийн судалгаагаар судалгааны талбайтай танилцах, хөрсний төлөөлөл болохуйц цэгүүдэд зүсэлт тавих, GPS-ийн хэмжилт авах, гадаргын болон хөрсний морфологи бичиглэл хийх, дээж авах зэрэг үйлдлийг гүйцэтгэхээс гадна тухайн талбайтай холбоотой хөрсний судалгааны материалтай танилцах хэрэгтэй байдаг. Эдгээр материал нь судалгааны талбайн талаарх хамгийн дэлгэрэнгүй, бодит мэдээлэл болох ба хөрсний төлөв байдал, доройтлыг тодруулах суурь материал юм.

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байрлах “Говийн шандаст хүлэг” ХХК-ийн уурхай, орд газрын талбайн хэмжээнд 15 ширхэг дээжлэлт хийсэн бөгөөд хөрсний хээрийн судалгааг 2023 оны 05-р сарын 23-ны өдөр гүйцэтгэсэн.

Хүснэгт 4. Хөрсний зүсэлт, дээжлэлт хийсэн цэгийн мэдээлэл

№	Дээж авсан цэгийн мэдээлэл	Уртраг	Өргөрөг	Өндөр д.т.д
S-1	Баяжуулах үйлдвэр	108.9889	46.1383	1250м
S-2	Бутлуур	108.9926	46.1328	1240м
S-4	Засварын төв	109.0090	46.1355	1241м
S-5	Карьер	109.0010	46.1310	1186м
S-6	ШТС	108.9878	46.1368	1252м
S-7	Овоолго	109.0074	46.1311	1275м
S-8	Хяналт дээж	108.9887	46.1388	1250м
S-10	Замын хажуу	108.9934	46.1328	1250м
S-11	Кемп	108.9888	46.1387	1250м
S-12	Шимт овоолго	109.0073	46.1361	1250м
S-13	Карьер 1	109.0124	46.1905	1265м
S-14	Овоолго	109.0119	46.1824	1288м
S-15	Шимт хөрсний овоолго	109.0097	46.1858	1285м
S-3	Хогийн цэг	108.9878	46.1368	1246м
S-9	Нүхэн жорлон	108.9875	46.1376	1250м



Зураг 7. Дээж авсан цэгүүдийн байршлын зураг

Зураг 8. S-3 цэг. Энгийн хог хаягдал

Зураг 9 S-4 Засварын төв

Зураг 10 S-5 Карьер

Зураг 11. S-6 ШТС

Зураг 12. S-7 Овоолго

Зураг 13. S-8 Хяналтын дээж

Зураг 14. S-9 Нүхэн жорлон

Зураг 15. S-10 Замын хажуу

Зураг 16. S-11 Кемп

Зураг 17. S-12 Шимт хөрс

Зураг 18. S-13 Карьер-2

Зураг 19. S-14 Овоолго

Зураг 20. S-15 Шимт хөрсний овоолго

3.2 ЛАБОРАТОРИЙН СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

Хээрийн судалгаагаар цуглуулсан хөрсний дээжийг Дээж хөрс судлалын лабораторид стандартын дагууд хуурай нөхцөлд хатааж 1 мм-ээр шигшиж лабораторийн задлан шинжилгээнд зориулан бэлдлээ. Хөрсний ерөнхий шинж чанарын үзүүлэлтүүд (pH, $CaCO_3$, ялзмаг, цахилгаан дамжуулах дамжуулах чанар, азот, солилцоот сууриуд, хөдөлгөөнт элементүүд механик бүрэлдэхүүн)-ийг лабораторид тодорхойлсон.

Хүснэгт 5. Хөрсний дээжний үзүүлэлтүүдийг шинжилсэн арга зүй, стандарт

Үзүүлэлт	Аргазүй	Стандарт
Дээж бэлтгэх, хатаах	Хуурай аргын нөхцөлд	Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга, MNS 3310:1991
Дээж шигших	1 мм	
pH	Хөрс:ус (1:2.5),pH метр	Хөрсний чанар. pH-ыг тодорхойлох MNS ISO 10390-2001
$CaCO_3$	Кальциметр, эзлэхүүний	Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох арга, MNS 3310:1991
Цахилгаан дамжуулах чадвар	Хөрс:ус (1:2.5),EC метр	
Органикийн агууламж	Тюрины, Бихроматын исэлдэлт	
Хөдөлгөөнт Фосфор, Кали	Мачигины арга	
Механик бүрэлдэхүүн	Пипеткийн арга	Качинскийн арга
Хүнд металл	Спектрометрийн арга	
Нянгийн бохирдол		

3.3 ХӨРСНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ҮНЭЛЭХ МЭДЭЭЛЭЛ

Хөрсний үржил шимт чанарын үзүүлэлтүүдийн түвшнийг олон улсын хэмжээнд ашигладаг үр дүнгийн зэрэглэлийн аль түвшинд байгааг тодорхой харуулах, үнэлэхийг зорилоо.

a) Хөрсний урвалын орчин: урвалын орчныг дараах зэрэглэлд ангилдаг (Soil survey manual. 1993. Chapter-3)

pH	5.6-6.0	6.1-6.5	6.6-7.3	7.4-7.8	7.9-8.4	8.5-9.0
Түвшин	Дунд зэрэг хүчиллэг	Сул хүчиллэг	Саармаг	Сул шүлтлэг	Дунд зэрэг шүлтлэг	Хүчтэй шүлтлэг

b) Хөрсний ялзмагийн агууламж: Олон улсын практикт хөрсний ялзмагийн агууламжаар нь маш бага буюу <1%, бага буюу 1-2%, дунд буюу 2-5%, их буюу >5% гэж хуваан авч үздэг (https://njaes.rutgers.edu/soil-testing-lab/organic-matter-levels.php)

c) Карбонатын агууламж: Үржил сайтай хөрсөнд карбонат илэрдэггүй.

Карбонат	0	0.1-2	2-10	10-25	>25

Түвшин	Карбонатгүй	Сул карбонаттай	Дунд зэрэг	Хүчтэй карбонаттай	Маш хүчтэй

d) Хөрсөн дэх давсжилт хөрсний чанарын чухал үзүүлэлт болдог бөгөөд цахилгаан дамжуулах чанар нь ургамлын ургац, ургамлын тохиромжтой байдал, ургамлын тэжээллэг чанар, хөрсний бичил биетний үйл ажиллагаанд нөлөөлдөг байна.

Давсжилт	**<0.75**	**0.75-2**	**2-4**	**4-8**	**8-15**	**>15**
Түвшин	Давсгүй	Сул давстай	Дунд зэрэг давстай	Өндөр давстай	Маш өндөр давстай	Хэт их давстай

e) Хөрсөн дэх хөдөлгөөнт элементүүдийг Мачигин аргазүйгээр тодорхойлсон бөгөөд аргазүйдээ хангамжийг ангилсан байдаг (мг/100 гр).

Фосфор	**<1**	**<1.5**	**1.5-3.0**	**3.0-4.5**	**4.5-6.0**	**>6.0**	**<1**
Түвшин	Хэт бага	Бага	Дунд	Дунд-с их	Их	Хэт их	Хэт бага
Кали	<10	10-20	21-30	31-40	41-50	50<	<10
Түвшин	Хэт бага	Бага	Дунд	Дундаас их	Их	Хэт их	Хэт бага

3.4 СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хээрийн судалгаагаар авагдсан нийт дээжнүүдийн лабораторийн задлан шинжилгээний үр дүнг нэгтгэн дүгнэж, судалгааны цэгүүдийн хөрсний шинж чанарыг товч тодорхойллоо.

Хүснэгт 6. Мониторинг цэгүүдийн хөрсний дээд үеийн агрохими шинж чанар

Дээжний дугаар	**pH**	**Давс (%)**	**ЦДЧ, (ds/m)**	**Ялзмаг (%)**	**$CaCO_3$ (%)**	**Солилцох сууриуд, мг-экв/100г**		**Шим тэжээлийн элементүүд, мг/100г**	
						Ca^{2+}	**Mg^{2+}**	**P_2O_5**	**K_2O**
S-1	7.26	0.41	0.675	-	-	13	6	0.7	35
S-2	7.22	0.39	0.771	-	-	12	5	0.3	42
S-4	8.17	0.31	0.287	0.34	-	12	8	1.1	34
S-5	7.27	0.39	0.485	-	-	12	8	1.1	37
S-6	8.16	0.23	0.458	0.38	-	10	5	1.1	28
S-7	8.21	0.35	0.391	0.44	-	11	6	1.3	30
S-8	8.41	0.09	0.183	1.5	-	12	6	3.1	52
S-10	8.21	0.08	0.253	1.3	-	13	7	2.8	51
S-11	8.19	0.09	0.385	1.7	-	12	7	3.1	49
S-12	8.39	0.1	0.21	1.6	-	13	5	2.9	45
S-13	7.41	0.26	0.381	-	-	13	9	1.3	34
S-14	8.34	0.28	0.195	0.44	-	11	9	1.3	32
S-15	8.13	0.09	0.354	1.4	-	12	8	2.5	49

3.4.1 Хөрсний химийн ерөнхий шинжилгээ



Зураг 21. Ялзмагийн агууламж

Хөрсний өнгөн үе буюу дээд үе давхарга (хээрт 0-20 см, говьд 0-5 см)-ын ялзмагийн агууламж 0-2% бага, 2-5% дунд зэрэг, 5%-иас дээш бол их ялзмагтай гэсэн ангилалд багтдаг. Судалгааны үр дүнд мониторинг цэгүүдийн хөрсний дээд үе давхарга дахь ялзмагийн агууламж 0.2-1.7%-ийн хооронд буюу бага ялзмагийн агууламжтай байна. Бүс нутгийн хөрсний ялзмагийн агууламж ерөнхийдөө 1-2%-ийн хооронд хэлбэлздэг.



Зураг 22. Урвалын орчин

Хөрсний урвалын орчин (pH) 6.1-6.5 сул хүчиллэг, 5.0-6.0 дунд зэрэг хүчиллэг, <5 хүчтэй хүчиллэг, 6.6-7.3 саармаг, 7.4-7.8 сул шүлтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүлтлэг, 8.5-9 хүчтэй шүлтлэг гэсэн ангилалд хуваах хөрсний урвалын орчинг үнэлдэг. Судалгаанд хамрагдсан цэгүүдэд саармагаас дунд зэрэг шүлтлэг урвалын орчинтой байна.



Зураг 23. Цахилгаан дамжуулах чанар

Хөрсний цахилгаан дамжуулах чанар буюу давсжилт <0.75 ds/m бол давсжилтгүй 0.76-2 ds/m бол сул давстай гэсэн ангилалд хамаарагддаг. Хөрсний давсжилт бага байх нь ургамал ургахад тохиромжтой гэж үздэг. Судалгаанд хамрагдсан нийт дээж давсжилтгүй гэсэн ангилалд багтаж байна.



Зураг 24. Хөдөлгөөнт фосфор (P_2O_5)-ын агууламж

Хөрсний хөдөлгөөнт фосфор нь хөрсний үржил шимт чанарыг илэрхийлэх нэг үзүүлэлт. Нийт судалгаанд хамрагдсан хөрсний хөдөлгөөнт фосфор (P_2O_5)-ын агууламж 0.3-3.1 мг/100г-ийн хооронд хэлбэлзэж байна. Хөрсний хөдөлгөөнт фосфорын агууламж дундаж агууламжтай байна.



Зураг 25. Хөдөлгөөнт кали (K_2O)-ын агууламж

Хөрсний хөдөлгөөнт кали (K_2O) нь хөрсний үржил шимийг илэрхийлдэг шим тэжээлийн голлох элементүүдийн нэг юм. Нийт судалгаанд хамрагдсан хөрсний хөдөлгөөнт кали (K_2O)-ийн агууламж 28.0-52.0 мг/100г-ын хооронд хэлбэлзэж байна. Нийт хөрсний дээжүүдэд хөдөлгөөнт калийн агууламж дунджаас өндөр түвшинд байна.

3.4.2 Хөрсний физик үзүүлэлт

Хөрсний механик бүрэлдэхүүн буюу ширхгийн бүрэлдэхүүнээс хөрсний физик, химии, биологийн олон шинж чанар хамаардаг чухал үзүүлэлт юм. Хөрсний ширхгийн бүрэлдэхүүнийг бүрдүүлж байгаа ширхгүүдийг элс, тоос, шаврын харьцаагаар буюу элс, тоос, шаврын фракцын аль нь давамгайлж байгаагаар тодорхойлдог. Уурхайн хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд физик шаврын эзлэх хувь 17-26% байгаа нь элсэнцэр болон хөнгөн шавранцар ширхгийн бүрэлдэхүүнтэй хөрс зонхилон тархсан байна. Физик шаврын хувь хэмжээнээс хамааран ширхгийн бүрэлдэхүүнийг нэрийг тодруулдаг бөгөөд физик шаврын агууламж 10-20% элсэнцэр, 20-30% хөнгөн шавранцар, 30-45 шавранцар, 45-60% хүнд шавар гэх мэтээр ангилдаг. Уурхайн үйл ажиллагааны нөлөөтэй газруудад хөрс элсэнцэр ширхгийн бүрэлдэхүүнтэй байна.

Хүснэгт 7. Механик бүрэлдэхүүн

Хөрсний механик бүрэлдэхүүн (%)							
Дээжний дугаар	**1-0.25мм**	**0.25-0.05мм**	**0.05-0.01мм**	**0.01-0.005мм**	**0.005-0.001мм**	**<0.001мм**	**<0.01мм**
S-1	42.6	18.2	12.8	14.5	8.2	3.7	26.4
S-2	57.1	9.2	10.2	13.6	7.2	2.7	23.5
S-4	40.6	29.1	12.9	9.2	5.4	2.8	17.4
S-5	37.1	24.6	15.9	12.1	7.4	2.9	22.4
S-6	50.9	20	9.5	9.1	5.6	4.9	19.6
S-7	43.5	26.3	11.5	8.9	6.1	3.7	18.7
S-8	27.6	32.9	16.5	9.9	5.2	7.9	23
S-10	28.1	31	17.2	11.5	6.4	5.8	23.7
S-11	37.9	27	12.9	9.8	5.3	7.1	22.2
S-12	41.3	21.4	11.4	10.7	6.5	8.7	25.9
S-13	36.1	23.1	17.1	11.9	8.5	3.3	23.7
S-14	38.7	29	13.6	8.9	6.1	3.7	18.7
S-15	29	30.7	18.3	12	5.7	4.3	22

3.4.3 Микробиологийн шинжилгээ

Микробиологийн шинжилгээг S-3 дугаартай хог хаягдлын орчмоос, S-9 нүхэн жорлон орчмоос авсан дээжинд тодорхойлоход: Бактерийн ерөнхий тоо стандартаас өндөр, нийт **цэгүүдэд** халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн таньц илэрсэн **илрэв (0.001)** бохирдлын зэргээр дунд зэргийн бохирдолтой, Клостридиум перфрингенсийн таньц **илрэв (0.01)** бохирдлын зэргээр бага зэргийн бохирдолтой, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян (Salmonella) нийт дээжинд илрээгүй.

Хүснэгт 8. Хөрсний микробиологийн үзүүлэлт

Дээжний дугаар	Мониторингийн цэгийн нэршил	Нянгийн нийт тоо	Гэдэсний бүлгийн савханцар (E.coli)	Анаэробын (Clostridium perfringens)	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч, (Salmonella)
S-3	Хогийн цэг	$3.9*10^6$	Илэрсэн (0.001)	илрэв (0.01)	илрээгүй
S-9	Нүхэн жорлон	$5.2*10^6$	Илэрсэн (0.001)	илрэв (0.01)	илрээгүй
Зөвшөөрөгдөх хэмжээ		***1 гр-д 10^6-с хэтрэхгүй***	***Илрэхгүй***	***Илрэхгүй***	***Илрэхгүй***

3.4.4 Хөрсний хүнд металл

Хөрсний бохирдлын гол үзүүлэлт болох хүнд металлууд нь задарч алга болдоггүй хөрсөнд удаан хугацаагаар хадгалагдаж ус болон ургамлаар дамжин хүн, мал, амьтны организмыг хордуулдаг. Амьд организм буюу хүн, амьтны биед удаан хугацаагаар хуримтлагдсанаас организмыг молекулын ба гений түвшинд хордуулдаг.

Хүнд металл гэж: нягт нь 5г/см^3-ээс илүү, атом масс нь 40-өөс илүү металлууд орно. Үүнд: Sc, Ti, V, Cr, Mn, Fe, Co, Ni, Cu, Zn, Ga, Rb, Sr, Y, Zr, Nb, Mo, Tc, Ru, Rn, Pd, Ag, Cd, In, Sn, Cs, Ba, La, Hf, Ta, W, Re, Os, Ir, Pt, Au, Hg, Ti, Pb, Fr, Ra, Ac зэрэг 42 элемент багтана. Химийн хувьд хүнд металлууд гэсэн бүлэг дотор хортой элементүүдээс гадна, хор нөлөө нь бага биологийн идэвх багатай олон элементүүд багтдаг.

Хортой хүнд металл: хүн, амьтан, ургамлын өсөлт хөгжилтөд сөрөг нөлөө үзүүлдэг, янз бүрийн өвчин үүсгэх эх үүсвэр болох ба эдгээрт: хар тугалга (Pb), зөөлөн цагаан (Cd), мөнгөн ус (Hg), хүнцэл (As), хром (Cr), зургаан валентат хром (Cr^{6+}), цайр (Zn), кобальт (Co), никель (Ni), зэс (Cu), стронций (Sr), ванадий (V) зэрэг 12 металл орно.

Хүнцэл (As): металл биш боловч хортой аюул нөлөө нь хүнд металлуудтай төстэй учраас хүнд металл гэсэн бүлэгт багтдаг.

Онцгой хортой органик биш бодисууд (хүнд металл): хар тугалга (Pb), зөөлөн цагаан (Cd), мөнгөн ус (Hg), хүнцэл (As), хром (Cr), зургаан валентат хром (Cr^{6+}), цианид (CN^-). Эдгээр нь амьд организмд учруулах хор нөлөөлөл ихтэй, амьд организмд их хэмжээгээр орсон тохиолдолд өвчин үүсгэх улмаар үхэлд хүргэх аюултай.

Био-идэвхт хүнд металл: зэс (Cu), цайр (Zn), хром (Cr), ванадий (V), никель (Ni), стронций (Sr), цагаан тугалга (Sn), анзан (Mo), селен (Se), бор (B), фтор (F) багтах бөгөөд хортой нөлөөллийн хувьд онцгой хортой хүнд металлууд (Pb, Cd, Hg, As)-аас арай бага, тодорхой хэмжээгээр амьд организмд байх ёстой боловч амьд организмд их хэмжээгээр хуримтлагдвал эндемик буюу оргономол өвчин үүсгэдэг аюултай.

Хүснэгт 9. Хөрсний хүнд металлын агууламж

Дээжний дугаар	Мониторингийн цэг	ЭЛЕМЕНТ, мг/кг										
		As	Cd	Co	Cr	Cu	Mo	Ni	Pb	Sr	V	Zn
S-1	Баяжуулах үйлдвэр	<3	<1	7	11	9.2	5	11	12	98.9	29	42
S-2	Бутлуур	<3	<1	4	8	8	6	6	11	108	20	21
S-4	Засварын төв	<3	<1	4	19	12.5	4	10	33	179	36	68
S-5	Карьер	8	<1	2	42	13.2	2	13	48	312	74	79
S-6	ШТС	<3	<1	4	17	10.2	2	7	48	204	33	72
S-7	Овоолго	4	<1	7	40	15.1	3	14	51	110	59	129
S-8	Хяналт дээж	<3	<1	4	21	7.4	1	9	33	146	35	55
S-10	Замын хажуу	<3	<1	4	20	8	<1	8	31	150	34	52
S-11	Кемп	<3	<1	3	12	7.6	<1	6	28	155	25	48
S-12	Шимт овоолго	<3	<1	4	17	8.9	<1	9	30	190	33	57
S-13	Карьер 1	9	<1	10	53	17	2	16	61	212	108	152
S-14	Овоолго	<3	<1	9	39	18.5	5	18	42	262	84	97
S-15	Шимт хөрсний овоолго	<3	<1	10	33	19	<1	18	30	478	80	87
MNS 5850 : 2019	Хүлцэх	20	3	50	150	100	5	150	100	800	150	300
	Хортой	50	10	500	400	500	20	1000	500	3000	600	600
	Аюултай	100	20	1000	1500	1000	50	1800	1200	6000	1000	1000
	Элсэнцэр хөрс	10	1	30	60	60	2	60	50	600	100	100



Зураг 26. Хүнцэл (As) мг/кг. Хэвтээ шугам нь
Монгол орны элсэрхэг хөрсний хүлцэх агууламж, зөвшөөрөгдөх дээд хэмжээг илэрхийлж байна.

Хүнцэл нь металл биш боловч хортой аюул нөлөө нь хүнд металлуудтай төстэй учраас хүнд металл гэсэн бүлэгт, онцгой хортой гэсэн ангилалд багтдаг. Нийт судалгаанд хамрагдсан дээжинд хүнцлийн агууламж 3.0-9.0 мг/кг-ийн хооронд хэлбэлзэж байна. Монгол улсын стандартад заасан хүнцлийн хүлцэх агууламж 20 мг/кг, элсэнцэр хөрснийх 10 мг/кг гэж заасан байдаг. Нийт цэгүүдэд элсэнцэр хөрсний стандарт хүлцэх агууламжаас бага байна.



Зураг 27 Хромын агууламж мг/кг Хэвтээ шугам нь
Монгол орны элсэрхэг хөрсний хүлцэх агууламжийг илэрхийлж байна.

Хром (Cr) нь онцгой хортой хүнд металлын ангилалд хамрагддаг. Нийт судалгаанд хамрагдсан хөрсний дээжинд хром (Cr)-ын агууламж 8-53 мг/кг хооронд хэлбэлзэж байна. Хром (Cr)-ын Монгол улсад мөрдөгддөг хөрсний хүлцэх агууламжийн хэмжээ 150 мг/кг, элсэнцэр хөрсний стандарт 60 мг/кг гэж заасан байдаг. Судалгаанд хамрагдсан дийлэнх дээжний хромын агууламж хүлцэх агууламжаас бага байна.



Зураг 28. Хартугалга агууламж мг/кг
Хэвтээ шугам нь Монгол орны элсэрхэг хөрсний хүлцэх агууламжийг илэрхийлж байна.

Хар тугалга нь Монгол улсын стандартаар онцгой хортой гэсэн ангилалд орох бөгөөд хөрсөнд ихэвчлэн исэл, сульфид байдлаар агуулагддаг. Хар тугалга нь хордлого үүсгэхдээ амьсгалын зам, залгих, арьс ба нүдэнд хүрэлцэх замаар дамжин даарч сульдах, нойргүйдэх, жингээ алдах, бүдүүн гэдэс рүү хатгах (colic), цус багадах, бугуй ба шагайн саа, тархины зовнил, бөөр өвдөх, нүд үрэвсэх, цусны даралт ихсэх зэрэг нөлөөлөл үзүүлдэг. Хөрсний судалгааны үр дүнгээс харахад хар тугалга (Pb)-ын агууламж 11-61.0 мг/кг хооронд хэлбэлзэх ба дийлэнх дээжинд элсэнцэр хөрсний хүлцэх агууламжаас бага, харин S-6 буюу ШТС, S-13-Карьерийн гадаргаас авсан дээжинд Хар тугалганы агууламж 51-61 мг/кг буюу элсэнцэр хөрсний хүлцэх агууламжаас өндөр, зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага түвшинд байна. Тухайн цэгт тос, масло хөрсөнд асгарснаас үүдэн дээрх элемент өндөр гарсан байх магадлалтай байна.



Зураг 29. Молибден (Mo) мг/кг
Хэвтээ тасархай улаан шугам нь Элсэнцэр хөрсний стандартыг илэрхийлж байна.

Молибден (Mo) хортой хүнд металл. Молибден (Mo)-ын Монгол улсын стандарт хэмжээ 5 мг/кг, элсэнцэр хөрснийх 2 мг/кг байдаг бол хортой агууламж 20 мг/кг байдаг. Судалгаанд хамрагдсан нийт дээжүүд Монгол орны хөрсний стандартын элсэнцэр хөрсний хүлцэх агууламжийг давсан бол 3 цэгт стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээ 5 мг/кг-аас өндөр буюу бохирдолтой байна. Эдгээр цэгүүд нь S-1 буюу Баяжуулах үйлдвэр, S-2 буюу Бутлуур, S-14 буюу Овоолгын дээжүүдэд Молибдены агууламж 5-6 мг/кг байна. Уурхайн чулуулаг тэр тусмаа нүүрс агуулагч чулуулагт Молибдены агууламж өндөр байх магадлалтай байна.

ДҮГНЭЛТ

Судалгаагаар нийт 15 цэгээс хөрсний өнгөн үе давхаргын дээж авч хими, физик, микробиологийн шинжилгээнд хамруулсан. Судалгаанд хамрагдсан бүх дээж ялзмагийн агууламж ерөнхийдөө багатай хөрстэй. Хөрсний урвалын орчин саармагаас дунд зэрэг шүлтлэг. Хөрс давсжилтгүй. Хөрсний физик шинжийн хувьд элсэнцэр болон хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүн давамгайлж байна. Микробиологийн шинжилгээгээр энгийн хог хаягдлын цэг, нүхэн жорлон орчмоос агааргүйтэн бичил биетний таньц, гэдэсний савханцрын таньц илэрсэн буюу нянгийн бохирдолтой. Хөрсний хүнд металлын бохирдлын хувьд Хар тугалга (Pb)-ийн агууламж Монгол улсын стандарт элсэнцэр хөрсний хүлцэх хэмжээнээс өндөр түвшинд, харин стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага агууламжтай бол Молибден (Mo)-ийн агууламж стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр буюу бохирдолтой харин хортой агууламжаас өндөр тохиолдол илрээгүй байна. Хүнцэл (As), Хром (Cr), Ванади (V), Цайр (Zn), Кадми (Cd), Кобальт (Co), Зэс (Cu), Никель (Ni), Стронци (Sr) хүлцэх хэмжээнээс бага агууламжтай байна.

ЗӨВЛӨМЖ

Уурхайн хэмжээнд орчны хяналт шинжилгээний цэгийг нийт талбайг болон үйл ажиллагааг төлөөлүүлэх байдлаар 5-с багагүй цэгт сонгож жилд 2 багагүй удаа иж бүрэн шинжилгээг өндөр нарийвчлалтай судалгаа шинжилгээний лабораториор шинжлүүлж, харьцуулан дүгнэж байх

Талбайн хэмжээнд хэд хэдэн элемент элсэнцэр хөрсний хүлцэх агууламжаас өндөр, мөн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байгаа нь уурхайн үйл ажиллагаа хөрсөн бүрхэвчид сөргөөр нөлөөлж буйн нэг илрэл бөгөөд цаашид хөрс бохирдуулах эрсдэлийг бууруулах тал дээр анхаарах

Хөрсийг шинээр хөндөх тохиолдолд хөрсний өнгөн хэсгийн 0-20 см хүртэлх зузаан хөрсийг шимт хөрсний талбайд хадгалах, үржил шимт чанарыг алдагдуулахгүй байх тал дээр анхаарах

Талбайн хэмжээнд хамгийн бага эвдрэл үүсгэж байхаар үйл ажиллагааг төлөвлөх: төлөвлөгөөг сайтар баримтлан ажиллах

Талбайн хэмжээнд нүхэн жорлон, стандартын шаардлага хангахгүй байгаа ариун цэврийн байгууламжийг уурхайн хэмжээнд хориглох

Уурхайн хөрс бохирдуулах эрсдэл бүхий ШТС, засварын газар, авто зогсоол, ариун цэврийн байгууламжуудыг хөрс, орчныг бохирдуулахгүй байх орчныг бүрдүүлэх тал дээр анхаарах

- Бохирдсон хөрсийг уурхай, хээрийн нөхцөл саармагжуулах талаар

Уурхайн хэмжээнд нянгийн бохирдолд орсон хөрсийг ариутгал халдваргүйжүүлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тал дээр анхаарч ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллах

- Хөрсийг ногоон байгууламж, модлог ургамал тарихад ашиглах боломжтой талаар хөрс талаас нь зөвлөмж өгнө.

Талбайн хөрс, хөрсөн бүрхэвч нь үржил шимийн хувьд ядмаг хэдий ч ус чийгийн хангамжийг сайн бүрдүүлж өгөх нь манай оронд ургадаг төрөл бүрийн мод, модлог ургамлыг тарих боломжтой.

БҮЛЭГ 4. АГААРЫН ЧАНАР, ТООСЖИЛТ

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байрлах “Говийн шандаст хүлэг” ХХК-ийн нүүрсний орд ашиглах уурхайн талбайн агаарын чанарын тоосжилтыг 2023 оны 5-р сарын 23-ны өдөр талбайн дотор дурын 4 цэгээс хэмжилт хийж гүйцэтгэв. Хэмжилтийн цэгийн байршлын координат болон зураглалыг доор харуулав.

Хүснэгт 10 Хэмжилт хийсэн цэгийн координат

Хэмжилтийн дугаар	Цэгийн нэршил	Координат:	
		Уртраг	Өргөрөг
А 1	Бутлуур	108.99255	46.13283
А-2	Шигшүүр	108.98860	46.14106
А-3	Технологийн зам	108.99343	46.13282
А-4	Кемп	108.98883	46.13865



Зураг 30. Агаарын тоосжилт хэмжсэн цэгийн байршил

Хэмжилт хийсэн багаж- Орчны агаар дахь PM 10 тоосонцрыг SidePak™ AM520 Personal Aerosol Monitor багажийн тусламжтайгаар хийж гүйцэтгэв.

Item Description	Part/Order Number	Reference Picture
AM520 Personal Aerosol Monitor (shown with battery pack)	AM520	
Battery Pack, 5400mAH	803300	
Single Carry Case 11.25" x 9" x 4.25" (28.6 x 22.9 x 10.8 cm)	1319289	
AM520 Impactor Kit (impactor oil, impactor disc (3x), Blank inlet, PM_1 inlet, $PM_{2.5}$ inlet, PM_5 inlet, PM_{10} inlet.)	803301	
Dorr-Oliver 10-mm Nylon Cyclone Kit	801701	
DPM Cyclone Kit	803303	

Зураг 31. SidePakTM AM520 Personal Aerosol Monitor

Энэхүү SidePak™ AM520 Personal Aerosol Monitor агаарын чанарын хяналтын багаж нь PM 10, PM 2.5 PM5, PM1 тоосонцрыг тодорхойлох боломжтой хэмжилтийн үр дүнг мг/м3 нэгжээр, хамгийн их утга, хамгийн бага утга, дундаж утга болон 8 цагийн дундаж гэсэн утгыг тодорхойлох хүчин чадалтай.

4.1 СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Агаарын чанарын хэмжилт хийсэн 4 цэгт том ширхэгт тоосонцрын хэмжээг MNS 4585 2016 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага стандарттай харьцуулан доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 11 Агаарын тоосны хэмжилтийн үр дүн

№	Хэмжилтийн цэг	Цэгийн нэршил	PM 10 мг/м^3
1	**А** 1	Бутлуур	0,006
2	**А**-2	Шигшүүр	0,092
3	**А**-3	Технологийн зам	0,073
4	**А**-4	Кемп	0,069
MNS4585:2016 зөвшөөрөгдөх дээд хэмжээ			**0,100**

ЗӨВЛӨМЖ

Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

Уурхайн үйл ажиллагааны турш:

- Тоосжилт бий болгох гол эх үүсвэрүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төслийн эхний үе шатанд төлөвлөн энэхүү сөрөг нөлөөллийг бууруулсан, Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж ашиглах
- Төслийн бүхий л үйл ажиллагааны явцад тоосжилтыг хянах бууруулах үр ашигтай бөгөөд практик ач холбогдолтой үйл ажиллагааны журмыг боловсруулан мөрдөх
- Уурхайн үйл ажиллагааг явуулахдаа Дэлхийн банкны эрүүл ахуйн стандартад тусгасан шаардлагууд болон хот суурин газрын агаарын чанарын Монголын Үндэсний Стандартад заасан хэмжээг хангахуйц байхаар төлөвлөлт хийх
- Уурхайн авто замуудыг дулааны улиралд болон тоос ихээр босох үед усалгаа хийж чийгшүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Уурхайн гадаад, дотоод тээвэрлэлтийн гол зам буюу технологийн зам маршрутыг тогтоох, замыг хатуу хучилттай болгох, цаашид арчилж тордох
- Хөрс хуулалт хийсэн дахин ашиглагдахгүй талбайг үржил шимт хөрсөөр хучиж, ургамалжуулах.
- Уурхайн үйл ажиллагаанаас агаарт тархах тоосны хэмжээг багасгах, салхиар дамжин суурьшлын бүс рүү тархахаас сэргийлж уурхайн эргэн тойронд ногоон байгууламж байгуулах.

Карьер үүсгэх, ачилт, тээвэрлэлтийн үед:

- Төсөл хэрэгжих явцад сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй айл өрхийн судалгаа гаргаж, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох.
- Хөрс хуулсан талбай болон эвдрэлд орсон газрын боломжтой хэсгийг нь тухай бүрд нь үржил шимт хөрсөөр хучиж, ургамалжуулах.
- Уурхайн ажлын талбай, дотоод шороон замыг үйл ажиллагааны туршид усаар чийглэж байх, зарцуулсан усны бүртгэл хөтлөх.
- Уурхайн дотоод, гадаад замыг тогтмол засаж сайжруулах, хатууруулагч бодис болон шинэлэг технологийг нэвтрүүлэх.
- Замын тэмдэг тэмдэглэгээ хийх, уурхайн дотоод замд тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах.
- Шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх, тогтсон маршрутаар тээврийн хэрэгслийг зорчуулж байх.
- Аливаа техник технологийн өөрчлөлт, шинэчлэлийг нэвтрүүлэхдээ байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах төлөвлөгөөтэй хамт хэрэгжүүлдэг байх.

Овоолго үүсгэх үед:

- Овоолгыг зонхилох салхины чиглэлийг харгалзан салхин дор байрлуулах.
- Газар шорооны ажлын технологийг хүнд машин механизмын жолооч нарт сургаж, үржил шимт хөрсний овоолго хийх, хэлбэржүүлэх, хадгалах ажлыг стандартын дагуу хийлгэх.

- Уурхайн шимт хөрсний болон гадаад овоолгын талбайг хуурай, салхи ихтэй, агаар мандал тогтворгүй үед байнга усалж байх хэрэгтэй.

БҮЛЭГ 5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2023 оны 5-р сарын 15-ны А/160 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Говийн шандаст хүлэг ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт байрлах Алаг тогоогийн нүүрсний орд ашиглах уурхайн талбайд хог хаягдлын цэг, хог хаягдлын хадгалалт, хамгаалалт болон холбогдох бичиг баримтын бүрдэлд хяналтын ажлыг гүйцэтгэсэн.

Уурхайн талбай дээр очих үед байсан төлөв байдлын зургийг доор харуулав.

Энгийн хатуу хог хаягдал-ын төвлөрүүлэх цэгт ангилан ялгалт хийгдээгүй, шаардлага хангасан хогийн сав байрлуулаагүй. Хог хаягдлын талаарх хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах шаардлагатай байна.

Зураг 32. Ахуйн хог хаягдлын цэг

Аюултай хог хаягдал - Аюултай хог хаягдал /ашигласан тос, масло/-ыг ил задгай стандартын шаардлага хангаагүй талбайд хаясан байв. Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулаагүй. Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар аваагүй. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын саванд хадгалаагүй. Аюултай хог хаягдал савлах хадгалах сав нэг бүрд “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэг, тэмдэглэгээ хийгдээгүй. Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалалтыг хийхдээ стандарт, холбогдох бичиг баримтын бүрдэл хангагдаагүй. Аюултай хог хаягдал үүсгэгч нь

цаашид хадгалж байгаа аюултай хог хаягдалтайгаа урвалд ордоггүй материалаар хийсэн, эсхүл доторлосон бат бөх зориулалтын саванд хадгалах шаардлагатай байна. Аюултай хог хаягдал байрлуулах талбайг асгарсан, алдагдсан хаягдал, хуримтлагдсан хур тунадсыг тогтоон барих хязгаарлалтын системийг хийж ажиллах нэн шаардлагатай байгааг харуулж байна.

Зураг 33 Аюултай хог хаягдлын цэг

Нүхэн жорлон

Уурхайн талбайд байрлах нүхэн жорлонг ариутгал халдваргүйжүүлэлт хийж устгах шаардлагатай байна. Мөн Нүхэн жорлон, угаадасны нүх Техникийн шаардлага MNS5924:2015 стандартын дагуу нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болж хөрс, ус бохирдох нөхцөлийг бууруулах шаардлагатай байна.

Зураг 34. Нүхэн жорлон

ЗӨВЛӨМЖ

Хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор аж ахуй нэгж нь үйл ажиллагаагаа эрхлэхдээ дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Хог хаягдлын тухай хуулийн 10.2.1 энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах;
2. Хог хаягдлын тухай хуулийн 10.2.2 энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хогийн савтай байх;
3. Хог хаягдлын тухай хуулийн 10.2.3 аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;
4. Хог хаягдлын тухай хуулийн 10.2.5 үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;
5. Хог хаягдлын тухай хуулийн 10.2.13 хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах;
6. Хог хаягдлын тухай хуулийн 10.2.14 хог хаягдлын талаарх хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;
7. Хог хаягдлын тухай хуулийн 10.2.17 үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;
8. Хог хаягдлын тухай хуулийн 10.2.18 аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авах, аюулгүй ажиллагааг хангах;
9. Хог хаягдлын тухай хуулийн 10.3 Иргэн, аж ахуй нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараах үйл ажиллагааг хориглоно. гэсэн заалтыг анхаарч ажиллах.
10. Хог хаягдлын тухай хуулийн 21.1 аюултай хог хаягдал үүсгэгч болон аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь энэ хуулийн 8.1.9а-д заасны дагуу бүртгүүлж, бүртгэлийн дугаар авсан байна.
11. Хог хаягдлын тухай хуулийн 22.1 Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын саванд савлаж хадгална.
12. Хог хаягдлын тухай хуулийн 22.2 Аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна.
13. Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах. гэсэн заалтыг дагаж мөрдөх.
14. Хог хаягдлын тухай хуулийн 33 дугаар зүйл. Аюултай хог хаягдал хадгалахад тавигдах нэмэлт шаардлага. гэсэн заалтыг дагаж мөрдөх.

БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ БАГЦ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Монгол Улсын байгаль орчны тухай хууль, журмын дагуу төсөл хэрэгжүүлэгч нь аливаа үйл ажиллагаа эхлүүлэхийн өмнө байгаль орчны суурь судалгаа, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний ажлуудыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, байгаль орны үнэлгээнд тусгагдсан байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдөн ажиллах үүрэгтэй. Энэхүү үүргийнхээ хүрээнд тус компани нь орчны хяналт шинжилгээний ажлыг үргэлжлүүлж тайлан гарган ажиллах шаардлагатай.

Уурхайн талбай дээр ажиллах үед байсан бичиг баримтын жагсаалтыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 12 Бичиг баримтын бүрдэл

№	Хуулийн заалт	Бичиг баримт	Бичиг баримтын бүрдэл хангагдсан эсэх
Усны тухай хуулийн хэрэгжилт			
